



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/357

Булган сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, “Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймаг дахь Төрийн аудитын газар (РД:3190269)-т Булган сумын 5 дугаар баг Гурилын үйлдвэр 1 дүгээр гудамж 106 тоотод байршилтай 4937677 төлөвлөлтийн дугаартай 933 м2 газрыг төрийн захиргааны байгууллага зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Булган аймаг дахь Төрийн аудитын газар (Д.Батцогт)-тай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010280